

## ЦАХИМ МӨНГӨНИЙ ТАТВАРЫН БҮРТГЭЛИЙН АСУУДЛУУД

Н.Дамдиндорж\*, Э.Ундармаа\*\*, Л.Хишигбаяр\*\*\*

**Хураангуй:** Цахим мөнгө буюу криптовалют (David Chaum, 1983) 1983 онд үүссэн бөгөөд 1989 оноос DigiCash (David Chaum, 1989) гэсэн анхны цахим төлбөр тооцооны хэрэгсэлийг АНУ-ын бичил төлбөр тооцоонд хэрэглэж эхэлсэн байна. Үүнээс хойш Bitcoin (Satoshi Nakamoto, 2009) гэх криптовалютын үүссэнээр арав гаруй жилийн дотор 1.2 их наяд ам долларын зах зээлийн үнэлгээтэй, дэлхийн криптовалютын зах зээлийнхээ 50 гаруй хувийг дангаар эзэлж буй криптовалют болоод байна. Тиймээс энэ зах зээл дээр байгаа криптовалютуудыг хэрхэн бүртгэж, татварыг ямар арга замаар ногдуулах талаар судлахыг зорьсон. Одоогоор дэлхийн бусад улс орнууд болон манай улсын татварын хууль эрх зүйн орчинд шууд хамаарах хууль байхгүй боловч боломжит арга замыг санал болгохоор зорьлоо. Судлаач бидний судалгаа нь цахим мөнгийг эзэмшиж байгаа талын татварын асуудлыг судлах ба хөрөнгийн татварыг ногдуулах боломжтой гэсэн төсөөлөлтэй байна.

**Түлхүүр үгс:** цахим мөнгө, татвар ногдуулалт, хөрөнгийн татвар

## TAXATION ISSUE OF CRYPTOCURRENCY

**Abstract:** Electronic money, or cryptocurrency, first appeared in 1983, and in 1989, the first electronic payment tool, DigiCash, began to be used for micropayments in the United States. Since then, with the emergence of the cryptocurrency Bitcoin, it has become a cryptocurrency that has a market value of 1.2 trillion US dollars and occupies more than 50% of the world's cryptocurrency market. Therefore, it is intended to study how to report and tax the cryptocurrencies on this market. Currently, there is no law that directly applies to the tax legal environment of other countries of the world or our country, but we intend to propose possible ways. The researcher believes that our study will examine the taxation issues of the party holding the electronic money and that it is possible to impose capital tax.

**Key words:** cryptocurrency, taxation, capital tax

---

\* МУИС, Бизнесийн сургууль, (E-mail): [damdindorj1230@gmail.com](mailto:damdindorj1230@gmail.com)


\*\* МУИС, Бизнесийн сургууль, (E-mail): [undarmaa.e@num.edu.mn](mailto:undarmaa.e@num.edu.mn)

\*\*\* МУИС, Бизнесийн сургууль, (E-mail): [khishigbayar.lkh@gmail.com](mailto:khishigbayar.lkh@gmail.com)

## 1. Цахим мөнгөний тухай ойлголт, төрөл

Крипто гэдэг үг нь “kryptus” гэсэн эртний Грек үгнээс гаралтай бөгөөд орчуулвал нуугдмал эсвэл хувийн гэсэн утгыг илэрхийлдэг байна. Криптовалют нь өөрийн блокчэйнд суурилан ажилладаг блокчэйн технологийн бүх давуу талыг агуулсан байдаг ба криптографийн аргаар хамгаалагдсан тул хуурамчаар үйлдэх, давхар зарцуулалт хийх боломжгүй байдгаараа онцлогтой. Хэрэглэгч хоорондын гүйлгээ нь peer-to-peer хийгдэх бөгөөд ямарваа нэгэн дундын зуучлагч, гуравдагч тал болон төв байгууллагын зохицуулалтгүй санхүүгийн үйлчилгээ авах боломжийг блокчэйн сүлжээ бий болгодог. Өнөөдрийн байдлаар криптовалютын зах зээл дээр 2.4 сая гаруй криптовалюта, 2,3 их наяд ([www.coinmarketcap.com](http://www.coinmarketcap.com)) ам долларын зах зээлийн үнэлгээтэй байгаа бөгөөд цаашид зах зээлийн багтаамж болон койнуудын тоо нэмэгдсээр байх боломжтой юм. Яагаад криптовалюта ингэж хурдацтай хөгжиж, өргөн цар хүрээг хамраад байна вэ гэвэл ирээдүйд төлбөр тооцоо, шилжүүлэг гэх мэт банкны систем болон уламжлалт мөнгийг орлох технологийн болоод үр ашгийн хувьд боломжтой гэж дэлхий нийт харж байна. Маш өндөр нууцлал, төвлөрсөн бус сервис, аливаа зохицуулагчид болон улс төрийн институт нийлүүлэлтийг нь хянадаггүй гэх мэт олон давуу талууд байна. Криптовалютыг технологийн талаас нь койн болон токен гэж ангилах бөгөөд койн нь өөрийн гэсэн блокчэйн дээр суурилсан байдаг бол токен нь бусад койны бий болсон блокчэйн (Ethereum, Neo, Waves, Lisk, Strtis) дээр бий болдгоороо ялгаатай. Койн болон токенийг дараах байдлаар ангилж болно.

Зураг 1. Цахим мөнгөний төрөл



Security token нь компани токен гаргаснаар мөнгө болон санхүүгийн хөрөнгө өгөх, санхүүгийн хэрэглүүрийг тааламжгүй нөхцөлөөр өөр аж ахуйн нэгжтэй солилцох үүрэг хүлээх эсвэл өөрийн өмчийн хэрэгслээр барагдуулах буюу барагдуулж болох гэрээний үүрэг хүлээж байвал санхүүгийн өр төлбөр, Equity token нь бүх өр төлбөрийг хассаны дараа аж ахуйн нэгжийн хөрөнгөнд үлдэх хувь оролцоог илэрхийлэх гэрээний үүрэг хүлээж байвал өмчийн хэрэглүүрт, Utility token нь бүтээгдэхүүн нийлүүлэх эсвэл үйлчилгээ үзүүлэх гэрээний үүрэг хүлээж байвал худалдан авагчтай байгуулсан гэрээний орлого гэж

ангилж болно. Дээрх тодорхойлолтуудын аль нэгэнд хамаарахгүй token байвал тодорхой бус хугацаа эсвэл дүн бүхий өр төлбөрөөр ангилж нөөц эсвэл үүргийн дунг хангалттай найдвартай хэмжих боломжгүй ба үүргийг барагдуулах эдийн засгийн үр өгөөж бүхий нөөцийг зарцуулах магадлал бага гэж үзэн болзошгүй өр төлбөрөөр ангилж болно. Эдгээр ангилал нь цахим мөнгө эзэмшигч талд түүний зорилгоос шууд хамаарах тул дараагийн бүлэгт дэлгэрэнгүй авч үзнэ.

## 2. Цахим мөнгөний татварын бүртгэл

Хөрөнгө оруулагч буюу цахим мөнгийг эзэмшиж байгаа тал уг хөрөнгийг бүртгэж тайлагнахдаа түүний зорилгоос хамааруулан өөр өөр байдлаар хүлээн зөвшөөрч болно. Бидний судалснаар криптовалюта буюу цахим мөнгийг биет бус хөрөнгө, санхүүгийн хөрөнгө, бараа материал зэрэг хөрөнгүүдээр хүлээн зөвшөөрч бүртгэж болох бөгөөд дараах хэмжилтийн үнэ цэнүүд хэрэглэгдэнэ.

Хүснэгт 1. Цахим мөнгөний хүлээн зөвшөөрөлт, татварын төрөл  
*capital gain tax*

№	Улс	Хүлээн зөвшөөрөлт	Татварын төрөл	Он
1	Австрали	Биет бус хөрөнгө	Хөрөнгийн татвар	2014
2	АНУ	Хөрөнгө	Хөрөнгийн татвар	2014
3	Англи	Хөрөнгө	Хөрөнгийн татвар	2014
4	Итали	Санхүүгийн хөрөнгө	Хөрөнгийн татвар	2018
5	Франц	Хөдлөх хөрөнгө	Хөрөнгийн татвар	2014
6	Канад	Бараа материал	Хөрөнгийн татвар	2014
7	Истони	Санхүүгийн хөрөнгө	Хөрөнгийн татвар	2014

Эх сурвалж: [https://www.researchgate.net/publication/340210271\\_Cryptocurrencies\\_and\\_Taxation](https://www.researchgate.net/publication/340210271_Cryptocurrencies_and_Taxation)

Санхүүгийн хөрөнгө гэдэг нь НББОУС 32 Санхүүгийн хэрэглүүр стандартад “мөнгө, өөр аж ахуйн нэгжийн өмчийн хэрэглүүр, өөр аж ахуйн нэгжээс мөнгө, бусад санхүүгийн хөрөнгө авах эсвэл өөрт ашигтай нөхцөлөөр солилцох гэрээний эрхийг хэлнэ” гэж заажээ. Хэрэв гэрээг эзэмшигчийн өмнө хариуцлага хүлээж байвал тухайн цахим мөнгөнийг санхүүгийн хөрөнгө гэж ангилан бүртгэж, тайлагнаж болно.

Харин бараа материал гэж үзвэл НББОУС 2 Бараа материал стандартад “бизнесийн хэвийн үйл ажиллагааны явцад худалдан борлуулахаар эзэмшиж байгаа, борлуулахын тулд үйлдвэрлэлийн процессод байгаа, үйлдвэрийн процесс эсвэл үйлчилгээ үзүүлэхэд ашиглан зарцуулагдах материал, хангамжийн зүйлсийг хэлнэ” гэж байна. Тиймээс зах зээлийн бизнесийн хэвийн үйл ажиллагаа гэдэгт тухайн цахим мөнгийг богино хугацаанд эзэмшдэг

трейдэрүүдийн үйл ажиллагаа хамаарах болно.

НББОУС 38 Биет бус хөрөнгө стандартад “биет шинж чанаргүй, тодорхойлж болохуйц мөнгөн бус хөрөнгийг хэлнэ” гэсэн байдаг бөгөөд цахим мөнгөний шинж чанарт хамгийн тохиромжтой байж болох тодорхойлолт юм. Нэгэнт хөрөнгө гэж ангилсан бол ирээдүйд эдийн засгийн үр өгөөж өгөхөөр хүлээгдэж байх, мөн өртгийг нь найдвартай хэмжих боломжтой байх ёстой юм.

Хэрэв цахим мөнгийг эзэмшигч нь хөрөнгө байдлаар хүлээн зөвшөөрвөл хөрөнгийн татвар ногдох бөгөөд хөрөнгийн татварын суурийг судлах шаардлага үүснэ. Хөрөнгийн татварын суурь нь хөрөнгийн дансны үнийг нөхөх үед аж ахуйн нэгжид орох ямар нэг татвар ногдох эдийн засгийн өгөөжөөс татварын зорилгоор хасагдах дүн юм. Хэрэв эдийн засгийн өгөөжид татвар ногдохгүй бол хөрөнгийн татварын суурь нь дансны үнэтэйгээ тэнцүү байна.

Судлаач бидний зүгээс манай оронд цахим мөнгийг санхүүгийн хөрөнгөөр хүлээн зөвшөөрч бүртгэх нь зохимжтой гэж үзэж байна. Санхүүгийн хөрөнгийг эзэмшиж байгаа зорилгоос нь хамааруулан ашиг алдагдлаарх бодит үнэ цэнийн арга, бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнийн арга, хорогдуулсан өртгийн аргуудаас сонгож хэрэглэнэ. Цахим мөнгөний хувьд ашиг алдагдлаарх бодит үнэ цэнийн аргыг хэрэглэх нь илүү тохиромжтой бөгөөд анх хүлээн зөвшөөрөхдөө өртгөөр бүртгэнэ. Дараа тайлант үедэд бодит үнэ цэнээр буюу тухайн цахим мөнгний зах зээлийн үнээр хэмжинэ. Анхны өртөг болон тайлант жилийн эцэс дэх бодит үнэ цэнийн зөрүүгээр тохируулга хийх бөгөөд энэхүү тохируулгын улмаас санхүүгийн тайлангаар хүлээн зөвшөөрсөн ашиг, алдагдлыг татварын зорилгоор хүлээн зөвшөөрөхгүй улмаас хөрөнгийн дансны үнэ болон татварын суурь хоорондын зөрүүнээс татварын түр зөрүүг бүртгэнэ. Түр зөрүүг а татвар ногдох түр зөрүү эсхүл хасагдах түр зөрүү үүснэ.

### *Хүснэгт 2. Татвар ногдох ба хасагдах зөрцү*

Дансны үнэ > Татварын суурь	Татвар ногдох түр зөрүү үүснэ
Дансны үнэ < Татварын суурь	Хасагдах түр зөрүү үүснэ
Дансны үнэ=Татварын суурь	Түр зөрүү үүсэхгүй

*Эх сурвалж: Сангийн сайдын 2020 оны 144 тушаалын 3 дугаар хавсралт*

Санхүүгийн хөрөнгийг данснаас хасах үед хуримтлуулан бүртгэж байсан хойшлогдсон татварын хөрөнгө эсвэл өр төлбөр нь тайлант оны татварын зардлыг өсгөх эсвэл бууруулах нөлөө үзүүлнэ.

Цахим мөнгийн худалдан авах үед өртгөөр нь бүртгэнэ.

Дт. Ашиг алдагдал бодит үнэ цэнээрх хөрөнгө оруулалт XXX

Кт. Мөнгөн хөрөнгө XXX

Санхүүгийн хөрөнгийн үнэлгээнээс үүссэн татварын нөлөөллийг дараах байдлаар бүртгэнэ

Тайлант хугацааны эцэст өртөг болон бодит үнэ цэнийн зөрүүгээр үнэлгээний гарз эсвэл үнэлгээний олзыг хүлээн зөвшөөрч, бодит үнэ цэнэ нь өртгөөс бага үед гарз, их үед олз хүлээн зөвшөөрнө.

### Хүснэгт 3. Хөрөнгө оруулалтын үнэлгээний олз(гарз)

Дт. Үнэлгээний гарз XXX	Дт. ААБҮЦХОруулалт XXX
Кт. ААБҮЦХОруулалт XXX	Кт. Үнэлгээний олз XXX

Татварын суурь болон дансны үнэ хоёрын зөрүүнээс татвар ногдох түр зөрүү эсхүл хасагдах түр зөрүү үүсч болно.

### Хүснэгт 4. Татвар ногдох болон хасагдах түр зөрцү цүсэх

Татвар ногдох түр зөрцү цүсэх цед		Хасагдах түр зөрцү цүсэх цед	
Дт. Орлогын албан татварын зардал XXX	Дт. Орлогын албан татварын зардал XXX	Дт. Орлогын албан татварын зардал XXX	Дт. Хойшлогдсон татварын хөрөнгө XXX
Кт. Орлогын албан татварын өглөг XXX	Кт. Хойшлогдсон татварын хөрөнгө XXX	Кт. Орлогын албан татварын өглөг XXX	Кт. Орлогын албан татварын өглөг XXX
Кт. Хойшлогдсон татварын өглөг XXX	Кт. Орлогын албан татварын өглөг XXX	Кт. Орлогын албан татварын өглөг XXX	Кт. Орлогын албан татварын өглөг XXX

Санхүүгийн хөрөнгийг борлуулах үед өмнө үүссэн татвар ногдох түр зөрүү болон хасагдах түр зөрүүнүүд хаагдана.

### Хүснэгт 5. Татвар ногдох болон хасагдах түр зөрцү хаах

Татвар ногдох түр зөрцү хаагдах цед		Хасагдах түр зөрцү хаагдах цед	
Дт. Орлогын албан татварын зардал XXX	Дт. Орлогын албан татварын зардал XXX	Дт. Орлогын албан татварын зардал XXX	Дт. Хойшлогдсон татварын хөрөнгө XXX
Дт. Хойшлогдсон татварын өглөг XXX	Кт. Хойшлогдсон татварын хөрөнгө XXX	Кт. Орлогын албан татварын өглөг XXX	Кт. Орлогын албан татварын өглөг XXX
Кт. Орлогын албан татварын өглөг XXX	Кт. Орлогын албан татварын өглөг XXX	Кт. Орлогын албан татварын өглөг XXX	Кт. Орлогын албан татварын өглөг XXX

Харин санхүүгийн хөрөнгийг борлуулах үед хөрөнгийн татвар ногдуулах ба аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 18 дугаар зүйлийн гуравт заасны дагуу борлуулсан үнээс худалдаж авсан үнэ болон худалдан

авахад төлсөн баримтаар нотлогдож байгаа шимтгэлийн дүнг хасаж, албан татвар ногдуулах орлогыг тодорхойлно. Тус хуулийн 20 дугаар зүйлийн нэгт 0-6 тэрбум төгрөгийн албан татвар ногдуулах тухайн жилийн орлого олсон тохиолдолд 10 хувиар, 6 тэрбум төгрөгөөс дээш албан татвар ногдуулах тухайн жилийн орлого олсон тохиолдолд 600 сая төгрөг дээр 6 тэрбумаас дээш давсан орлогод 25 хувиар хөрөнгийн татвар ногдуулна.

## **Дүгнэлт**

Бидний судалснаар дэлхийн бусад улс орнуудад цахим мөнгийг өөр өөр татварын зүйл болгон хүлээн зөвшөөрч бүртгэж, татвар ногдуулж байна. Тиймээс манай орны хувьд бусад орнуудын туршлага дээр үндэслэн өөрийн орны онцлог, хууль эрх зүйн орчинд тохируулан хүлээн зөвшөөрч, татвар ногдуулах нь зүйтэй. Бидний судалгааны үр дүнгээр цахим мөнгийг эзэмшигч нь санхүүгийн хөрөнгөөр хүлээн зөвшөөрч, тэр дундаа ашиг алдагдлаарх бодит үнэ цэнийн аргыг бүртгэлдээ ашиглах нь зохистой гэж үзлээ. Энэ төрлийн санхүүгийн хөрөнгийн дараа тайлант үеийн хэмжилтээр бий болсон өртөг бодит үнийн зөрүү нь санхүүгийн тайлангаарх татварын өмнөх ашиг болон татварын тайлангаарх татвар ногдох орлогод зөрүү үүсгэж байна. Эдгээр зөрүүг санхүүгийн тайланд хойшлогдсон татварын хөрөнгө эсвэл өр төлбөрөөр хүлээн зөвшөөрч, уг санхүүгийн хөрөнгийг данснаас хасах хүртэл санхүүгийн тайланд тайлагнаж байна. Харин тухайн санхүүгийн хөрөнгийг данснаас хасах үед хуримтлуулан бүртгэж байсан хойшлогдсон татварын хөрөнгө эсвэл өр төлбөр нь тайлант оны татварын зардлыг өсгөх эсвэл бууруулах нөлөөлөл үзүүлнэ. Санхүүгийн хөрөнгийг борлуулах үед хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлогоор татварын зүйл болгож борлуулсан үнийн дүнгээс худалдан авсан үнэ болон баримтаар нотлогдож байгаа худалдан авахад төлсөн шимтгэлийн дүнг хасч татварын суурийг тооцоолох нь тохиромжтой гэж үзлээ.

**Ашигласан материал**

- Deloitte. (2024). Swiss taxation of cryptocurrency-how are investors taxed. <https://blogs.deloitte.ch/tax/2024/01/swiss-taxation-of-cryptocurrencies-how-are-investors-taxed.html>
- Ektha Surana. (2024). Taxation on Cryptocurrency: Guide to crypto taxes in India 2024. <https://cleartax.in/s/cryptocurrency-taxation-guide>.
- OECD. (2020). Taxing Virtual Currencies: An Overview of Tax Treatments and Emerging Tax Policy. Paris: [www.oecd.org/tax/tax-policy/taxing-virtual-currencies-an-overview-of-tax-treatments-and-emerging-tax-policy](http://www.oecd.org/tax/tax-policy/taxing-virtual-currencies-an-overview-of-tax-treatments-and-emerging-tax-policy) .
- Sahadi, J. (2021). Yes, the IRS can tax bitcoin and other cryptocurrencies. What you need to know.
- Sahin, I. O. (2018). Cryptocurrencies and taxation. *5th. international annula meeting Sosyoekonomi society*: Sahin, Isil Orkunoglu.
- Stickcharts. (2021). *Stickcharts*. Гаргасан 2021 оны 11 11, <https://www.slickcharts.com/symbol/MSFT-aac>
- Ulyanova, K. (2018). *Legal Regulation of the Crypto-Currency Taxation*. Belarusi State KPMG. (2019). *Crypto assets-Accounting and Tax*. <https://assets.kpmg.com/content/dam/kpmg/xx/pdf/2019/04/cryptoassets-accounting-tax.pdf>